

Зөв шударгад хамаарах зүйлүүд

Далын Ахлагч Франциско Ж.Биньяс

Бурханы үйлчлэгчдийн гэрчлэлийн дараа газар хөдлөлтийн болон бусад үйл явдлуудын тухай гэрчлэл дагалдах болно гэдгийг Сургаал ба Гэрээнд бидэнд хандан өгүүлсэн байдаг. “Мөн бүх зүйл үймээнд байх болно, мөн хүмүүний зүрх сэтгэл мохох нь гарцаагүй болно; учир нь бүх хүмүүс дээр айдас ирэх болно” (С ба Г 88:91).

Би Карибын Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүний хувьд айдсыг итгэлээр сольсон итгэлтэй Гэгээнтнүүдийн гэрч болсон хүн юм. Гайтид тохиолдсон явдлыг Мормоны Номон дахь түүхүүдтэй адилтгаж болох юм.

“Энэ нь бүх нутаг даяар . . . агуу гашуудал, харуусал сонсогдсон үе байв” (Алма 28:4) гэсэн Алмагийн хорин наймдугаар бүлгийн үгсийг тэрхүү аймшигт сүйрэл, өөрийн эрхгүй санагдуулж билээ. Хоёр зуун мянга гаруй хүн амь эрсдэж, “мөн олон мянга нь төрөл төрөгсдөө алдсандаа гашуудаж байв” (Алма 28:11).

Дөчин хоёр гишүүн амь эрсдэж, тэдний гэр бүл, найз нөхөд “төрөл төрөгсдөө алдсандаа гашуудан байх зуураа ч тэд Бурханы баруун гар талд оршихоор, хэзээ ч төгсөхгүй аз жаргалын байдалд босгогдсоныг Их Эзэний амлалтуудын дагуу тэд найдвартаа баясан мөн хөөрч, мөн бүр мэдэж байв.” (Алма 28:12).

Сүм орон нутгийн санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчдын удирдлага чиглүүлэл дор гишүүд, гишүүн бус хүмүүст яаралтай тусламжийг тэр даруйд илгээсэн юм. Тэд эм, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс, эн тэргүүний хэрэгцээт бусад зүйлсийг иргээсэн төдийгүй бас орон нутгийн удирдагчид тэдэнд зөвлөгөө, удирдамж өгч, сэтгэл санааг нь тайвшруулж байлаа. Дэлхий даяарх Сүмийн гишүүд тэдэнд дэмжлэг үзүүлж, “гашуудах тэдний хамт гашуудаж, тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулж байв” (Мозая 18:9).

Янз бүрийн үед олон бошиглогч “аймшигт үхэл ёс бусыг үйлдэгчдийн дээр ирнэ; учир нь тэд зөв шударгад хамаарах зүйлүүдийн хувьд үхмэл юм; учир нь тэд цэвэр бус, мөн ямар ч цэвэр бус зүйл Бурханы хаант улсыг өвлөж чадахгүй” (Алма 40:26) хэмээн сургамжтай бөгөөд ойлгомжтой эмгэнэлт явдлаас биднийг урьдчилан сэрэмжлүүлж байлаа.

Нифай энэ зарчмыг ах нартаа зааж, “өөрсдийн ёс бус үйлэнд насыг юүлвэл . . . тэд зөв шударгад хамаарагдах оюун санааны тэр зүйлүүдэд зайлуулагдах ёстой” (1 Нифай 15:33) гэж хэлсэн байдаг.

Лемен хүн, бошиглогч Самуел, “наманчлахгүй хэн боловч тас цавчигдаж, мөн галд хаягдах болно; мөн тэдний дээр сүнсний үхэл дахин ирнэ, тийм ээ, хоёр дахь үхэл, учир нь тэд зөв шударгад хамаарагдах зүйлүүдийн хувьд дахин тусгаарлагдах болно” (Хиламан 14:18) гэжээ.

Сүнсний зүйлүүдийн хувьд үхэхийн эмгэнэл нь “нэгэнт Бурханы Сүнсээр гэгээрүүлэгдсэний дараа мөн зөв шударгад хамаарах зүйлсийн агуу мэдлэгтэй

байсны дараа мөн тэгээд нүгэл болоод зөрчилд унасан . . .[хүмүүст], тэд илүү хатуурч, мөн тэдний байдал хэрэв тэд эдгээр зүйлсийг хэзээ ч мэдээгүй байснаас дор” (Алма 24:30) болж илүү их зөрчилд ордог байна.

Эцэг эхчүүд удирдагчид бид сүнсний үхэлд хүргэх зүйлсээс хол байхад нь манай гишүүд, гэр бүлүүдэд анхаарал тавьж, туслах хэрэгтэй. Бид бас эдүгээ сүнсний зүйлүүдэд үхмэл байгаа хүмүүст “дахин төрж; тийм ээ, Бурханаар дахин төрж, эгэл хийгээд унасан байдлаасаа зөв шударга байдалд орж өөрчлөгдөн, Бурханаар гэтэлгэгдэж, түүний хөвгүүд, охид болоход нь” (Мозая 27:25) тусалж, тэднийг аврахыг хүсдэг билээ.

Зөв шударгад хамаарах зүйлүүдэд үхмэл болсон хүмүүсийн сүнсний эдгэрэлт нь цагаатгалын хүч, үнэнд хөрвөгдөх болон зөв шударгын зарчмуудад чин үнэнч байснаар ирдэг билээ.

Зөв шударгад хамаарах зүйлүүдийг манай гишүүд, гэр бүлүүдэд заах нь хөрвөлтийн урт удаан үйл явцын нэн чухал хэсэг учраас энэ нь Их Эзэний зарлигуудын тухай сайн мэдээний зарчмууд болон сургаалууд, Их Эзэний хаант улсад авралыг олохын тулд бидний хийлгэх ёстой ёслолуудын тухай зөв мэдлэг эзэмшихэд хөтөлдөг.

Баттай хөрвөлтөд хүрэхэд туслах “зөв шударгад хамаарагдах зүйлүүдийг” заахын чухлыг нотолсон олон жишээ судруудад байдаг. Леменчүүдэд сайн мэдээг номлосон Аммон болон түүний ах нарын тухай шастирт:

“Мөн Аммон Лемонай хааны хүмүүст номлов; мөнхүү улиран тохиох дор тэрээр тэдэнд зөв шударгад хамаарах бүх зүйлүүдийн талаар заасан болой. Мөн тэр байдгаараа хичээнгүйлэн өдөр бүр тэдэнд ухуулж байв; мөн тэд Бурханы зарлигуудыг дагахдаа мэрийтгий байв” (Алма 21:23).

Зөв шударгад хамаарах бүх зүйлийг хичээнгүйлэн заахын үр дүнг бид дээрх шастирын 23, 27-р бүлгүүдээс, “итгэсэн болгон нь өөрөөр хэлбэл, Аммон болон түүний ах дүүсийн номлолоор, илчлэлт хийгээд бошиглолын суу билгийн, мөн тэднээр дамжуулан гайхамшгуудыг үйлдэх Бурханы хүчний дагуу Их Эзэнд хөрвүүлэгдэн . . . хэзээ ч итгэл алдраагүй” (Алма 23:6) тухай уншиж болно.

Эцэг Алма Сүмийг байгуулж, зохистой эрчүүдийг “өөрийн хүмүүсийг харж хандсан, мөн тэднийг зөв шударгад хамаарах зүйлүүдээр дэмжин асарсан болой” (Мозая 23:18).

Зөв шударгад хамаарах зүйлүүдийг ойлгоход хүүхдүүдээ туслахад эцэг эхчүүд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэр үед газар аваад байсан алдас, дайн дажин, зөрчил сөргөлдөөний улмаас гашуудаж, ард түмнийх нь зүрх сэтгэл хатуурсанд санаагаар унасан Алма, “зөв шударгад хамаарах зүйлүүдийн талаар өөрийн захиасыг тэдэнд тус тусад нь өгч болохын тулд хөвгүүдээ цугларах болгосныг” (Алма 35:16; налуу бичлэг нэмэгдсэн) бид Мормоны Номоос мэддэг билээ.

Тэрээр хүүхдүүдийнхээ хэрэгцээнд тохируулан, заах зүйлээ хөвгүүддээ тус бүрд нь өөр байдлаар өгснийг ажиглахад сонин юм. Тэрээр гэрчлэлээ хуваалцаж, сургаал,

зарчмуудыг тэдэнд зааж, эдгээр сургаал, зарчмуудыг бусдад заахад тэднийг бэлтгэсэн ажээ.

Гэр бүл хилэнцэт хүчний дайралтанд өртөж, бидний амьдардаг орчин нөхцөл Алмагийн үеийнхээс эрс өөр болсон үед Тэргүүн Зөвлөл, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийг гаргасан юм. Уг тунхагт “Эцэг эхчүүд хүүхдүүдээ хайр болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлэх ариун үүрэгтэй юм” гэж заажээ.

Энэхүү үүрэгт хүүхдүүд баг бөх итгэлтэй байж, үнэнээр бүсээ чанга бүслэхийн тулд зөв шударгад хамаарах бүх зүйлээр тэднийг хүмүүжүүлж, урам дэм хайрлан, зааж, “зөв шударга ёсны хуяг дуулгыг [өмсүүлэн], амар амгалангийн сайн мэдээний бэлтгэлийг [тэдний] хөлд өмсүүлэх нь” (С ба Г 27:16) ордог.

Яг Алмагийн үеийнх шиг манай удирдагчид Сүмийн гишүүдэд анхаарал тавьж, *зөв шударгад хамаарах зүйлсээр* тэднийг дэмждэг. Эдгээр зүйлс баттай хөрвөлтөнд хүрэхэд бидэнд туслах болно. Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын Чуулга 2009 оны 12-р сарын 10-нд хянан засварлаж гаргасан “Leadership Training Emphasis” баримт бичигт “гэр бүлийн гишүүн бүр, эцэг эх, хүүхэд бүрийг судруудыг судалж, тогтмол залбиран, Есүс Христийн сайн мэдээгээр амьдрахад нь урамшуулан дэмжихийг” санваартны болон туслах бүлгүүдийн удирдагчдаас хүссэн юм.

Судруудыг судалж, тогтмол залбиран, Есүс Христийн сайн мэдээгээр амьдрах нь зөв шударгын үйлс бөгөөд, “зөв шударгын үйлсүүдийг хийх тэрээр шагналаа, бүр энэ амьдралд амар амгаланг, ирэх дэлхийд мөнх амьдралыг хүлээн авах болно” (С ба Г 59:23) гэсэн гайхамшигт амлалтыг Их Эзэн илчилсэн юм.

*Зөв шударгад хамаарах зүйлүүдийг* илүү үр өгөөжтэйгөөр заахын тулд, бид мэдээлэл хуваалцахаас илчлэлтэд дэмжлэг үзүүлэх ёстой. Ийм замаар сургаалыг заалгаж байгаа хүн эдгээр зарчмуудыг өөрөө мэдэж авах хүсэлтэй болно.

Их Эзэн Хайрум Смитэд түүний дүү Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан: “Оюуныг чинь гэгээрүүлж, сүнсийг чинь баяраар дүүргэх Сүнснээсээ би чамтай хуваалцах болно.

“Мөн тэгээд чи мэдэх болно . . . зөв шударга ёсны зүйлүүдэд хамаарах юуг ч бай бүх зүйлийг хүлээж авна гэсэн итгэлээр итгэн чи надаас хүсвэл чи үүгээр мэдэх болно” (С ба Г 11:13-14) гэж илчилжээ.

Эцэст нь зөв шударга зүйлсийг хийхээ болохын аюулын тухай, Бурханы Сүнсээр гэгээрсэн хэрнээ урвалт, гэм нүгэлд унасан хүмүүст энэ нь илүү ноцтой үр дагавар авчирдгийг судрууд бидэнд сэрэмжлүүлдэг билээ.

*Зөв шударгад хамаарах зүйлүүдийг* заах нь үнэнийг мэдэж аван, хөрвөгдөж, Христэд итгэх итгэлдээ эцсийг хүртэл бат бөх зогсоход хүмүүст туслах чухал хүчин зүйл болдог.

*Зөв шударгад хамаарах зүйлсийг* үр хүүхэддээ заах ариун үүрэг эцэг эхчүүдэд байдаг. Удирдагчид, багш нар анхаарал халамж тавьдаг гишүүддээ *зөв шударгад хамаарах бүх зүйлсийг* хичээнгүйлэн зааснаар тэдэнд дэмжлэг үзүүлж чадна.

Хэрэв заах явцад илчлэлтэд түлхэц үзүүлж чадвал илүү үр дүнд хүрнэ. Ийнхүү энэ нь Сүнсээр гэгээрэх хүслийг хүмүүст төрүүлэх болно. Тэгсэн тохиолдолд *зөв шударгад хамаарах зүйлсийг* Сүнс ухааруулах болно гэдгийг итгэлээрээ мэдрэх болно.

Эдгээр зүйлсийг би Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен.